# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2026/022/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:

davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт ....................4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................6-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....................10
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....................10
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....................10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....................10-11
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт....................11-12
   3.5 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл....................12-15
4. Аудитын тайлан ....................18
   4.1 Ерөнхий зүйл ....................18
   4.2 Материаллаг байдал ....................18
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....................18
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................18
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................19
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................19
5. Аудитын илрүүлэлт .................... 19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл....................19-20

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар |
| ТТЗ | Төсвийн Төвлөрүүлэн Захирагч |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 01/321

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.ГАНБААТАР ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд 155.5 сая төгрөгийн тогтмол зардалтай холбоотой өр төлбөр үүссэн нь суманд мөрдөх халаалтын үнэ тарифыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс нэмэгдүүлэн баталсны улмаас улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардалтай холбоотой өр үүссэн, мөн жилийн дундуур батлагдсан төсөвт хасах тодотгон хийж тогтмол зардлыг бууруулж тодотгосонтой холбоотой дээрх өр төлбөр нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар 80.0 сая төгрөгийн 1 алдаа, 16.7 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Шинэ-Идэр сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2025 оны үр дүнгийн гэрээг 6 зорилт, 166 арга хэмжээтэй байгуулж, хэрэгжилтийг 93.0 хувьтай хангаж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 574,601.2 | 680,145.9 |
| Мөнгөн хөрөнгө | 316,138.3 | 241,335.4 |
| Авлаг | 176,293.3 | 209,804.7 |
| Бараа материал | 82,169.5 | 229,005.7 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,418,669.9 | 2,366,951.2 |
| УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 0 | 80,000.0 |
| Үндсэн хөрөнгө | 2,418,669.9 | 2,286,951.2 |
| Биет хөрөнгө | 2,374,718.3 | 2,244,864.9 |
| Биет бус хөрөнгө | 43,951.6 | 42,086.3 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН | 2,993,271.2 | 3,047,097.1 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | 62,914.1 | 276,033.7 |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 62,427.1 | 275,546.7 |
| Өглөг | 62,427.1 | 275,546.7 |
| УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 486.9 | 486.9 |
| Урт хугацаат зээл | 486.9 | 486.9 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,930,357.1 | 2,771,063.4 |
| Засгийн газрын хувь оролцоо | 2,930,357.1 | 2,771,063.4 |
| Засгийн газрын оруулсан капитал | 953,041.1 | 953,041.1 |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 838,676.4 | 873,676.4 |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 24,539.5 | 24,539.5 |
| Хуримтлагдсан үр дүн | 630,977.6 | 435,370.4 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 483,122.4 | 484,435.9 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 2,993,271.2 | 3,047,097.1 |

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 1,678,464.7 | 1,676,326.7 |
| ТАТВАРЫН ОРЛОГО | 626,619.9 | 640,659.1 |
| Орлогын албан татвар | 549,560.6 | 552,322.9 |
| Хувь хүний орлогын албан татвар | 549,560.6 | 552,322.9 |
| Хөрөнгийн албан татвар | 48,045.3 | 50,392.3 |
| Бусад татвар, төлбөр, хураамж | 29,013.9 | 37,943.7 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | -264,967.2 | 1,035,667.6 |
| Хөрөнгийн орлого | 15,000.0 | 0 |
| Тусламжийн орлого | 0 | 1,122,260.2 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,316,812.1 | 0 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,476,941.3 | 1,871,933.8 |

| | | |
|---|---|---|
| УРСГАЛ ЗАРДАЛ | 1,476,941.3 | 1,871,933.8 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,430,107.3 | 1,817,802.1 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 739,484.6 | 940,698.1 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 91,569.1 | 137,554.9 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 97,399.5 | 207,832.3 |
| Хангамж, бараа материалын зардал | 62,472.4 | 111,676.4 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 44,610.5 | 41,172.2 |
| Томилолт, зочны зардал | 4,560.75 | 3,189.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 113,825.5 | 118,998.4 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 276,184.7 | 256,679.7 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 46,834.00 | 54,131.7 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 201,523.4 | (195,607.1) |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 8,000.0 | 0 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | (8000.0) | 0 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 193,523.4 | (195,607.1) |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,069,787.8 | 2,054,433.5 |
| ТАТВАРЫН ОРЛОГО | 626,619.9 | 640,659.1 |
| Орлогын албан татвар | 549,560.6 | 552,322.9 |
| Хөрөнгийн албан татвар | 48,045.3 | 50,392.3 |
| Бусад татвар, төлбөр, хураамж | 29,013.9 | 37,943.7 |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж | 4,254.8 | 4,986.1 |
| Газрын төлбөр | 5,312.5 | 5,623.0 |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 19,446.5 | 27,334.5 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 126,355.8 | 1,413,774.4 |
| Нийтлэг татварын бус орлого | 111,355.8 | 186,518.8 |
| Хөрөнгийн орлого | 15,000.0 | 0 |
| Тусламжийн орлого | 0 | 1,122,260.2 |
| Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0 | 104,995.4 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,316,812.1 | 0 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,664,288.2 | 1,891,663.4 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 1,664,288.2 | 1,891,663.4 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,617,454.2 | 1,837,531.7 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 925,453.8 | 1,163,348.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 145,227.8 | 141,319.9 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 123,204.1 | 180,978.9 |
| Хангамж, бараа материалын зардал | 196,122.1 | 219,296.5 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 36,746.5 | 42,147.23 |
| Томилолт, зочны зардал | 4,560.7 | 3,189.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 83,274.2 | 26,758.1 |

| | | |
|---|---|---|
| Бараа үйлчилгээний бусад зардал | 102,865.0 | 60,493.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 46,834.0 | 54,131.7 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 405,499.5 | 162,770.0 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 0 | 400 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 221,175.1 | 157,972.9 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 221,175.1 | 157,972.9 |
| Дотоод эх үүсвэрээр | 221,175.1 | 157,972.9 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -221,175.1 | (157,572.9) |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 0 | 80,000.0 |
| САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 0 | 80,000.0 |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 184,324.4 | (74,802.8) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 131,813.8 | 316,138.3 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 316,138.3 | 241,335.4 |

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| **Дансны нэр, төрөл** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** | **Нийт цэвэр хөрөнгө /өмч** |
|---|---|---|
| 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 2,584,698.6 | 2,584,698.6 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 42,650.4 | 42,650.4 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,627,349.0 | 2,627,349.0 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (41,515.44) | (41,515.4) |
| Өмчид гарсан өөрчлөлт | 151,000.0 | 151,000.0 |
| Тайлант үеийн үр дүн | 193,523.4 | 193,523.4 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,930,357.1 | 2,930,357.1 |
| 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,930,357.1 | 2,930,357.1 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,930,357.1 | 2,930,357.1 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 36,313.5 | 36,313.5 |
| Тайлант үеийн үр дүн | (195,607.16) | (195,607.1) |
| 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 2,771,063.4 | 2,771,063.4 |

### 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| **Дансны нэр, төрөл** | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 219,268.0 | 0.0 | -219,268.0 | |
| **НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | 1,863,921.2 | 2,000,152.8 | 136,231.6 | 107.3 |
| НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,863,921.2 | 2,000,152.8 | 136,231.6 | 107.3 |
| Татварын бус орлого | 1,863,921.2 | 2,000,152.8 | 136,231.6 | 107.3 |
| Нийтлэг татварын бус орлого | 86,900.0 | 72,415.3 | -14,484.7 | 83.3 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 83,400.0 | 58,994.0 | -24,406.0 | 70.7 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 3,500.0 | 13,421.3 | 9,921.3 | 383.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тусламжийн орлого | 1,669,772.1 | 1,822,742.1 | 152,970.0 | 109.2 |
| Төсвөөс санхүүжих | 1,669,772.1 | 1,822,742.1 | 152,970.0 | 109.2 |
| Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 107,249.1 | 104,995.4 | -2,253.7 | 97.9 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 107,249.1 | 104,995.4 | -2,253.7 | 97.9 |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,083,189.2 | 2,009,273.6 | -73,915.6 | 96.5 |
| НИЙТ ЗАРЛАГА | 1,999,789.2 | 1,929,273.6 | -70,515.6 | 96.5 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 1,830,228.1 | 1,787,500.6 | -42,727.5 | 97.7 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,777,602.4 | 1,735,668.9 | -41,933.5 | 97.6 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 943,807.4 | 940,698.1 | -3,109.3 | 99.7 |
| Үндсэн цалин | 503,283.6 | 519,984.1 | 16,700.5 | 103.3 |
| Нэмэгдэл | 398,971.9 | 368,393.6 | -30,578.3 | 92.3 |
| Урамшуулал | 41,551.9 | 52,320.4 | 10,768.5 | 125.9 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 119,473.1 | 118,729.7 | -743.4 | 99.4 |
| Тэтгэврийн даатгал | 81,720.6 | 81,393.4 | -327.2 | 99.6 |
| Тэтгэмжийн даатгал | 9,438.1 | 9,350.4 | -87.7 | 99.1 |
| ҮОМШӨ-ний даатгал | 4,719.1 | 4,671.9 | -47.2 | 99.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 4,719.1 | 4,671.9 | -47.2 | 99.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 18,876.2 | 18,642.1 | -234.1 | 98.8 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 545,239.3 | 536,368.2 | -8,871.1 | 98.4 |
| Гэрэл, цахилгаан | 52,176.9 | 45,550.6 | -6,626.3 | 87.3 |
| Түлш, халаалт | 487,796.5 | 485,751.6 | -2,044.9 | 99.6 |
| Цэвэр, бохир ус | 5,265.9 | 5,065.9 | -200.0 | 96.2 |
| Хангамж, бараа материалын зардал | 36,972.0 | 24,731.4 | -12,240.6 | 66.9 |
| Бичиг хэрэг | 4,100.0 | 2,727.2 | -1,372.8 | 66.5 |
| Тээвэр, шатахуун | 27,500.0 | 17,852.2 | -9,647.8 | 64.9 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000.0 | 2,640.0 | -360.0 | 88.0 |
| Ном, хэвлэл | 372.0 | 0.0 | -372.0 | - |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000.0 | 1,512.0 | -488.0 | 75.6 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 42,554.0 | 42,147.2 | -406.8 | 99.0 |
| Урсгал засвар | 42,554.0 | 42,147.2 | -406.8 | 99.0 |
| Томилолт, зочны зардал | 3,500.0 | 2,425.0 | -1,075.0 | 69.3 |
| Дотоод албан томилолт | 3,500.0 | 2,425.0 | -1,075.0 | 69.3 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,351.9 | 17,076.3 | -7,275.6 | 70.1 |
| Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | 21,661.9 | 15,227.6 | -6,434.3 | 70.3 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150.0 | 0.0 | -150.0 | - |
| Даатгалын үйлчилгээ | 1,000.0 | 990.8 | -9.2 | 99.1 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 240.0 | 0.0 | -240.0 | - |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200.0 | 0.0 | -200.0 | - |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 900.0 | 857.9 | -42.1 | 95.3 |
| Газрын төлбөр | 200.0 | 0.0 | -200.0 | - |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 61,704.7 | 53,493.0 | -8,211.7 | 86.7 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 60,298.4 | 52,200.0 | -8,098.4 | 86.6 |
| Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал | 1,406.3 | 1,293.0 | -113.3 | 91.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 52,625.7 | 51,831.7 | -794.0 | 98.5 |
| Бусад урсгал шилжүүлэг | 52,625.7 | 51,831.7 | -794.0 | 98.5 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,141.7 | 51,141.7 | 0.0 | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,484.0 | 690.0 | -794.0 | 46.5 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 169,561.1 | 141,773.0 | -27,788.1 | 83.6 |
| Бусад хөрөнгө | 169,561.1 | 141,773.0 | -27,788.1 | 83.6 |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 83,400.0 | 80,000.0 | -3,400.0 | 95.9 |
| Эргэж төлөгдөх зээл | 83,400.0 | 80,000.0 | -3,400.0 | 95.9 |
| ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | -219,268.0 | -9,120.8 | 210,147.2 | 4.2 |
| АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | -219,268.0 | 9,120.8 | 228,388.8 | (4.2) |
| Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | -219,268.0 | 9,120.8 | 228,388.8 | (4.2) |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -219,268.0 | 103,302.2 | 322,570.2 | (47.1) |

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тайлант он |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 11,648.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 11,648.0 |
| 122 | Тусламжийн орлого | 11,648.0 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 11,648.0 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 11,648.0 |
| 350013 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,300.0 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,313.0 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 11,648.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 11,648.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,348.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,583.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,463.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 120.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 764.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 764.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,000.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,300.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,300.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,300.0 |

# 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон гүйцэтгэлийн үнэлгээгээр санхүүждэг улсын төсвийн 4 байгууллагын тогтмолын зардал, харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 ААН, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Шинэ-Идэр сумын 2025 оны санхүүгийн тайлангийн

аудитаар Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газарт 4 байгууллага түүвэрт хамрагдаж, 2 байгуулагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт хүргүүлсэн, 4 байгууллагын СТА-ийг хувийн АХЭ-ээр гэрээгээр гүйцэтгүүлэн дүгнэлт гаргуулан ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 80.0 сая төгрөгийн 1 алдаа, 16.7 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэн. Аудитын явцад 1 алдааг залруулж, 3 зөрчилд зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

### 5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага хүргүүлээгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой**

*1.1 Аудитын илрүүлэлт:* Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 6 иргэнтэй холбоотой 16.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай болон Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:* Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

2. **Өр төлбөртэй холбоотой холбоотой асуудлын талаар**

*2.1 Илрүүлэлт:* Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 275.5 сая төгрөгийн өр төлбөр үүсч, өмнөх оноос 213.1 сая төгрөгөөр нэмэгдсэн ба түүнийг барагдуулахтай холбоотой арга хэмжээг авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.”төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
*2.2 Өгсөн зөвлөмж:* Үүссэн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, цаашид өр төлбөр үүсэхгүй байхад анхаарч, халаалтын зардлыг нэмэгдсэн үнэ тарифаар санхүүжүүлэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийж ажиллах.

3. **Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой**

*3.1 Илрүүлэлт:* Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд тайлант онд нийт 145 мэдээлэл оруулахаас 136 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 6 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлж, мэдээлэх хугацаа болоогүй 3 мэдээлэл байна. Энэ нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3.*”тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”* заалт болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*3.2 Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийн хугацаанд мэдээллийг үнэн зөвөөр, иж бүрэн оруулан ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.”Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Урт хугацаат зээлийг богино хугацаат зээлийн авлагаар бүртгэсэн. | 1 | 80,000.0 | | | 1 | 80,000.0 | 1 | 80,000.0 | | | | |
| Харьяа байгууллагуудын зөрчил | | | | | | | | | | | | |
| Төсвийн байгууллагын нэмэлт орлогыг Үр дүнгийн тайланд буруу тусгасан. | 1 | 35.0 | | | 1 | 35.0 | 1 | 35.0 | | | | |
| Үнийг шинэчлэн тогтоохдоо хөрөнгө дутуу бүртгэсэн | 1 | 250.0 | 1 | 250.0 | | | 1 | 250.0 | | | | |
| **Дүн** | **2** | **285.0** | **1** | **250.0** | **1** | **35.0** | **2** | **285.0** | | | | |

### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд | 1 | 16,710.5 | | | | | 1 | 16,710.5 |
| Халаалт дулааны өр, бусад өр төлбөр | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **2** | 16,710.5 | | | | | **2** | 16,710.5 |
| Харьяа байгууллагуудын зөрчил | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нярвын дансаар дамжуулан үйл ажиллагааны зардлыг гаргасан. | 1 | 10,300.0 | | | | | 1 | 10,300.0 |
| Баяр наадмын зардлын бараа материалыг шууд зардалд тусгасан. | 1 | 1,463.2 | | | | | 1 | 1,463.2 |
| Бараа материалын бүртгэлд хөрөнгийн шинж чанартай зүйлс бүртгэсэн. | 1 | - | | | | | 1 | - |
| Бараа материалын үлдэгдлийг тоолоход бараа материалыг бодитоор худалдан аваагүй. | 1 | 360.0 | 1 | 360.0 | | | | |
| **Дүн** | 4 | **12,123.2** | 1 | 360.0 | | | 3 | 11,763.2 |

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн данс мэдээлийг хугацаа хоцроон мэдээллэсэн. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | **1** | **-** | | | | | **1** | - |
| Харьяа байгууллагуудын зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн, үнэн зөвөөр мэдээллэх | 1 | - | | | | | 1 | - |
| Дотоод хяналтын нэгжийг шинэчлэн байгуулаарж, хяналтын ажлыг төлөвлөсөн арга хэмжээнд иж бүрэн хэрэгжүүлэх. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **2** | | | | | | **2** | |

## 5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 10 | 5 | 4 | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | 1 | | | 1 | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | | | | | | | | |